

3.1 ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага ИНТОСАИ нь 1953 онд байгуулагдсан. Эгнээндээ 193 орны Аудитын дээд байгууллагуудыг нэгтгэсэн Засгийн газар хоорондын байгууллага юм.

1996 ОН

Төрийн аудитын байгууллага ИНТОСАИ-н бүрэн эрхт гишүүнээр элссэн.



АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГУУДЫН
ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА ИНТОСАИ

Аудитын дээд байгууллагуудын Азийн байгууллага нь 1979 онд байгуулагдаж, өдгөө 46 улс гишүүнээр элсээд байна.

1996 ОН

Төрийн аудитын байгууллага АСОСАИ-н бүрэн эрхт гишүүнээр элссэн.



АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГУУДЫН
АЗИЙН БАЙГУУЛЛАГА АСОСАИ

ИНТОСАИ-н Хөгжлийн санаачилга нь Аудитын дээд байгууллагуудын мэргэжлийн чадавхийг бэхжүүлэх, сайн засаглалыг хөгжүүлэх, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулагджээ.

1996 ОН



ИНТОСАИ-Н ХӨГЖЛИЙН
САНААЧИЛГА (АЙ ДИ АЙ)

Байгаль орчны аудитын ажлын хэсэг нь байгаль орчны аудитын аргачлалын ашиглалтыг сайжруулах, хил орчмын байгаль орчны асуудал, бодлогын хэрэгжилтэд хамтарсан аудит хийх, байгаль орчны олон улсын гэрээнд аудит хийх зэрэгт анхаарлаа хандуулж ажилладаг.

2004 ОН

Төрийн аудитын байгууллага Байгаль орчны аудитын ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байна.



ИНТОСАИ-Н ДЭРГЭДЭХ БАЙГАЛЬ
ОРЧНЫ АУДИТЫН АЖЛЫН ХЭСЭГ

ИНТОСАИ-н Олборлох аж үйлдвэрийн ажлын хэсэг нь Аудитын дээд байгууллагуудыг олборлох аж үйлдвэрлэлд ил тод, үр дүнтэй хяналт тавихад хувь нэмрээ оруулж, Засгийн газруудад байгалийн баялгийг олон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн удирдахад нь туслах үүрэгтэй юм.


2015 ОН

Монгол Улсын Үндэсний аудитын газар нь уг ажлын хэсэгт гишүүнээр ажиллаж байна.



ИНТОСАИ-Н ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН
АЖЛЫН ХЭСЭГ

ХОЁР ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА



ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУД

Төрийн аудитын байгууллагын чадавхийг бэхжүүлэх, сайн засаглалыг хөгжүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байна.



ДЭЛХИЙН
БАНК



АЗИЙН
ХӨГЖЛИЙН
БАНК



ЕВРОПЫН
ХОЛБОО



ТИКА



НҮБ-ИЙН
ХӨГЖЛИЙН
ХӨТӨЛБӨР



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ЖАЙКА



КОЙКА